**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 05 өдөр Дугаар А/138 Мандалговь

Эрчим хүчний хамгаалалтын
зурвас тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн нутаг дэвсгэрт эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, хүн амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын эзэмшилд байгаа дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасыг хавсралтаар баталсугай.

2. Хамгаалалтын зурвасыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Говийн бүсийн салбар (Н.Бямбадорж) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/289 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4822100309

Аймгийн Засаг даргын 2022 оны 04-р сарын
05 –ны өдрийн А/132 дугаартай захирамжийн
хавсралт

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ЭЗЭМШИЛД БАЙГАА ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАМААРАХ ДЭД СТАНЦ, ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСЫН ХЭМЖЭЭ

1. **Дэд станц:**

| д/д | Дэд станцын нэр | Дэд станцын хашааны хэмжээ | | | Хамгаалалтын зурвасын хэмжээ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өргөн /м/ | Урт /м/ | Талбай /м$^2$/ | Өргөн /м/ | Урт /м/ | Талбай /м$^2$/ |
| 1 | 110/35/10 кВ Мандалговь дэд станц | 75.4 | 78.3 | 5903.82 | 95.4 | 98.3 | 9377.82 |
| 2 | 220/110/35 кВ Мандал дэд станц | 175 | 220 | 38500 | 195 | 240 | 46800 |

2. **Цахилгаан дамжуулах агаарын шугам:**

| д/д | Цахилгаан дамжуулах агаарын шугамын нэр | Шугамын нийт урт /км/ | Хэлхээний тоо | Хамгаалалтын зурвасын хэмжээ | Хаагуур дайран өнгөрөх |
|---|---|---|---|---|---|
| 1 | 220 кВ Чойр-Мандалговь | 91.8 | 1 | Шугамын захын утаснаас 2 тийш /**25 м**/ | Говь-Угтаал |
| 2 | 220 кВ Мандалговь-Тавантолгой | 248.9 | 2 | Шугамын захын утаснаас 2 тийш /**25 м**/ | Луус, Хулд, Өлзийт |
| 3 | 330 кВ Сонгино-Мандалговь | 248.5 | 2 | Шугамын захын утаснаас 2 тийш /**30 м**/ | Дэлгэрцогт |

**Жич:** “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-д зааснаар шугам сүлжээ, дэд станцын хамгаалалтын зурвас нь доорх хэмжээтэй байна.
110 кВ-н Дэд станцын хамгаалалтын зурвасын хэмжээ:

- Дэд станц, хуваарилах байгууламжийн хашаанаас тал бүр тийш – **20 м**

220 кВ-н Дэд станцын хамгаалалтын зурвасын хэмжээ:

- Дэд станц, хуваарилах байгууламжийн хашаанаас тал бүр тийш – **25 м**

220 кВ-н Цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасын хэмжээ:

- Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд шугамын захын утаснаас 2 тийш – **25 м**
- Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд шугамын захын утаснаас 2 тийш – **6 м**

330 кВ-н Цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасын хэмжээ:

- Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд шугамын захын утаснаас 2 тийш – **30 м**

Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд шугамын захын утаснаас 2 тийш – **10**